



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар Д/141

Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, 34.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд ган, зудын эрсдэлийг даван туулахын тулд бусад аймгуудад отор нүүдэл хийж өвөлжсөн малчдыг малын гоц халдварт өвчний голомт бүртгэгдсэн нутгаас буцан ирэх үед гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнгын хяналт тавьж байхад нэн шаардлагатай явуулын лабораторийн зориулалтаар ашиглах дунд оврын автобус, дагалдах хэрэгслийн жагсаалтыг нэгдүгээр, явуулын лабораторид ажиллах ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглах компьютер, техник хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар, шинжилгээ хийхэд шаардагдах багаж, тоног төхөөрөмж, урьдчилсан оношилгоонд хэрэглэгдэх тестийг худалдан авах зардлын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийн нэгдүгээр хавсралтад заагдсан дунд оврын автобус дагалдах хэрэгслийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга (З.Балданням), хоёр, гуравдугаар хавсралтад заагдсан албаны техник хэрэгсэл, лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авч, явуулын лабораторийг тоноглож, ажил үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа)-д тус тус даалгасугай.

3.Явуулын лабораторийн автобус, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авахад зарцуулагдах 35,230,000 (гучин таван сая хоёр зуун гучин мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100304

Аймгийн Засаг даргын 2021 оны...<sup>03</sup>  
дугаар сарын 24...-ны өдрийн...<sup>24</sup>...дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЯВУУЛЫН ЛАБОРАТОРИЙН АВТОБУС ДАГАЛДАХ  
ХЭРЭГСЭЛ

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо	Шалгуур үзүүлэлт	Зах зээлийн дундаж үнэ /мян төгрөг/
1	Автобус	ш	1	БНСУ-д үйлдвэрлэсэн дунд оврын автобус	18000.0
2	Үлээдэг /халаагуур/ тенн	ш	2	Стандартын шаардлага хангасан.	500.0
	Нийт дүн				18500.0

-оОо-



Аймгийн Засаг даргын 2021 оны 03.  
дугаар сарын 24-ны өдрийн 44 дүгээр  
захирамжийн хоёрдугаар хавсралт



ЯВУУЛЫН ЛАБОРАТОРИД ШААРДЛАГАТАЙ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үнэ /мян.төг/
1	Лабораторийн ширээ	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	700.0
2	Компьютер /зөөврийн/	ш	1	Сүүлийн үеийн багтаамж сайтай, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна.	2600.0
3	Принтер	ш	1	Гурван үйлдэлт	450.0
4	Дуут дохио	ком	1	Мал эмнэлгийн зориулалт бүхий	580.0
6	Халдвар хамгааллын хувцас хадгалах битүүмжлэл бүхий шүүгээ	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	350.0
7	Гар халдваргүйжүүлэх зориулалт бүхий угаалтуур	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	250.0
8	Ажилтнуудын ээлжээр амрах ор	ш	2	Эвхдэг ор, уутан хөгжил	600.0
9	Гал тогооны хэрэгсэл, газын плитка, /4-5 хүний аяны хоол ундны ком/	ком	1	5-10 литрийн багтаамжтай баллонтой газын плитка	300.0
10	Мотор /Цахилгаан үүсгүүр/	ш	1	Өндөр хүчин чадалтай ачаалал даах чадвартай байх	1850.0
Дүн					6980.0

Аймгийн Засаг даргын 2021 оны...03...  
дугаар сарын 24...-ны өдрийн...1/4... дүгээр  
захирамжийн гуравдугаар хавсралт



ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Д/д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үнийн дүн /мян төгрөг/
1	РН метр	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	1900.0
2	Нийлүүлгийн өвчний тест	ш	100	Стандартын шаардлага хангасан байна.	600.0
3	Зөөврийн термостат	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	1200.0
4	Зөөврийн автоклав	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	1300.0
5	Зөөврийн бактерцитны ламп	ш	1	Стандартын шаардлага хангасан байна.	600.0
6	ДХХ нянгийн эпсилон хор илрүүлэх түргэн тест	ш	100	Стандартын шаардлага хангасан байна.	1850.0
7	Шүлхийн түргэн тест	ш	20	Стандартын шаардлага хангасан байна.	1980.0
8	Галзуугийн түргэн тест	ш	20	Стандартын шаардлага хангасан байна.	320.0
Дүн					9750.0

-oOo-